



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/353

Булган сум

### Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.10, Батлан хамгаалахын сайдын 2023 оны н/41 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтийг хангах, Батлан хамгаалах, хууль тогтоомж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэд, хүүхэд залуучуудад сурталчлах, “Бидний бахархал” төсөл арга хэмжээг 2023 оны 05 дугаар сарын 18-наас 26-ны хооронд зохион байгуулсугай.

2. “Бидний бахархал” төслийг зохион байгуулахад оролцох ажлын хэсгийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 46.932.000 (дөчин зургаан сая есөн зуун гучин хоёр мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

4. Батлан хамгаалахын хууль тогтоомжийг сурталчлах, “Бидний бахархал” төслийн арга хэмжээг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулахад холбогдох албан тушаалтнуудыг томилж ажиллуулах, бие бүрэлдэхүүнийг байрлуулах болон бусад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхийг Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлагууд, зарим агентлаг, хэлтсийн дарга нар, сумдын Засаг дарга нар, Цэргийн штаб (дэд хурандаа Ч.Энхбаяр)-т тус тус даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010365

Аймгийн Засаг даргын 2023 оны 05-р сарын  
05-ны өдрийн А/33 тоот захирамжийн  
нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн ахлагч:

Д.Алтаншагай  
(Аймгийн Засаг даргын  
газрын дарга)

(Аймгийн Засаг даргын тамгын  
тамгын дарга)

Гишүүд

Г.Эрдэнэбаяр (Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн  
захирагч, хурандаа)

М.Эрдэнэбуян (Хилийн цэргийн 0286 дугаар ангийн  
захирагч, хурандаа)

Ш.Баасандорж (Онцгой байдлын газрын дарга,  
хурандаа)

Д.Төгсбаяр (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын  
дарга, хурандаа)

Л.Ганбаатар (Цагдаагийн газрын дарга, цагдаагийн  
хурандаа)

Л.Алтанцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын  
газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга)

Х.Энхбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийтлэг үйлчилгээний албаны дарга)

П.Нөхөрлөлбаяр (Булган сумын Засаг дарга)

Ж.Ганболд (Боловсрол шинжлэх ухааны газрын  
дарга)

Х.Батхишиг (Биеийн тамир спортын газрын дарга)

П.Оюунцэцэг (Нэгдсэн эмнэлэгийн даргын үүргийг  
түр орлон гүйцэтгэгч)

А.Гантөмөр (Байгаль орчин, аялал жуулчлалын  
газар)

Г.Алдармөнх (Соёл, урлагийн газар)

Т.Бэхтөр (Булган аймгийн музейн дарга)

Ж.Халиунаа (Хөгжимт жүжгийн театрийн дарга)

Г.Ганбаатар ("Булган-Мээж" ОНӨХХК-ий захирал)

Бүх сумдын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга:

д/х Ч.Энхбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын  
газрын Цэргийн штабын дарга)



Аймгийн Засаг даргын 2023 оны 05-р сарын  
09-ны өдрийн А/352 тоот захирамжийн  
хоёрдугаар хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧЛАХ "БИДНИЙ  
БАХАРХАЛ" ТӨСЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН  
ТООЦОО

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Бүгд	Тайлбар
1	Аннос	ш	144.000	12	1.728.000	3*4 харьцаатай
2	Буудал	Хүн	50.000	113*3 хон	16.950.000	
3	Хоол /Хүнс/	Хүн	15.500	430*3 хон	19.995.000	
4	Ус	ш	1.800	20 кроп	864.000	
5	Ундаа	ш	2.000	15 кроп	360.000	
6	Кофе, цай	ш	20.000	10	200.000	
7	Нэг удаагийн аяга	ш	7.500	20	150.000	
8	Ааруул	ш	20.000	10	200.000	
9	Өрөм	ш	20.000	10	200.000	
10	Тугны суурь шинэчлэх /тросс/	ш	27.000	6	165.000	
11	Гэрийн цагаан бүрээс /6 хантай гэрийн дотор гадар/	ш	250.000	1	250.000	
12	Урилга	ш	1.500	250	375.000	
13	Цэцэг /хөшөөнд өргөх дурсгалын цэцэг/	ш	150.000	2	300.000	
14	Тууз	ш	70.000	5	350.000	
15	Шаардагдах шатахуун	Литр	2.520	750	1.890.000	Бэлтгэл ажил, сумдаар тойрох
16	Хүндэтгэлийн өргөө	ш	50000	50	2.500.000	
17	Түлшний мод	ш	500.000	1	500.000	1 машин
Нийт					46.932.000	